

Жамсранжавын Баярсайхан^{1✉}, Хүрэлчулууны Баасансүрэн²

¹Шинжлэх Ухааны Академийн Археологийн хүрээлэн,
Монгол улс, Улаанбаатар-13330, Энхтайваны өргөн чөлөө,
Шинжлэх Ухааны Академийн хүрээлэнгүүдийн нэгдсэн I байр

²Соёл, урлаг, аялал жуулчлал залуучуудын газар,
Монгол улс, Хөвсгөл аймаг, Мөрөн сум, 8-р баг,
Аймгийн захиргааны Б корпус

Монголын умард нутгаас шинээр илрүүлсэн буган хөшөөд

Хураангуй. Монгол улсын умард бүс Хөвсгөл аймгийн нутгаас 2022-2023 оны хооронд шинээр илрүүлэн, бүртгэн баримтжуулсан гучин буган хөшөөний талаар энэхүү судалгаанд авч үзлээ. Эдгээр буган хөшөөдийн ихэнх нь буюу 90 хувь нь амьтны дүрслэлгүй буган хөшөөд байгаа нь тухайн бүс нутгийн онцлогийг илэрхийлж байна. Зарим буган хөшөөнд уг соёлын хүрээнд маш цөөн тохиолдох гүйвэр зэвсэг дүрсэлснээс гадна Шивээтийн буган хөшөөнд урьд өмнө буган хөшөөнд огт тохиолдож байгаагүй агсарга унжлагатай бүс, олон цувраа хонхор цэгээр илэрхийлсэн титэм, нүүрэн талд дүрсэлдэг гурван ташуу зураасыг төлөөлүүлсэн гурван хонхор цэг зэргийг дүрсэлсэн нь уг соёлын судалгааг баяжуулсан маш чухал, шинэ баримтууд болж байна.

Түлхүүр үг: Хурлийн үе, буган хөшөө, Монголын умард нутаг, агсарга бүс, гүйвэр зэвсэг

Bayarsaikhan Jamsranjav^{1✉}, Baasansuren Khurelchuluun²

¹Institute of Archaeology, Mongolian Academy of
Sciences, Building-1, Peace avenue, Ulaanbaatar
13330, Mongolia

²Head of the Culture Division at the Khuvsgul
Provincial Department of Culture, Arts, Tourism, and
Youth, Khuvsgul, Mongolia

Unveiling Newly Discovered Deer Stones of Northern Mongolia

Abstract. This study presents thirty newly discovered and documented deer stones from Khuvsgul Province in northern Mongolia, recorded during the 2022–2023 field seasons. The majority of these monuments—approximately 90 percent—without animal depictions, a pattern that represents a distinctive regional characteristic of northern Mongolia. Several examples also bear engravings of bola weapons, a motif that is exceptionally rare within the broader deer stone tradition. Of particular significance is the Shiveet deer stone, which displays several previously undocumented features in deer stone art: a belt with multiple suspended objects, a diadem or headband rendered as a series of small circular hollows, and three circular depressions that appear to symbolize the three oblique lines typically carved on the front face. Together, these findings provide important new evidence for understanding the diversity, stylistic variation, and regional development of Deer Stone culture.

Keywords: Bronze Age, deer stone, Northern Mongolia, belt with multiple suspensions, ancient bola weapon

Монгол нутаг дахь эртний соёл өвийн дурсгалуудын дотроос тэнгэр, газрыг холбон сүндэрлэх буган хөшөө хэмээх гайхамшигт чулуун дурсгал нь эртнээс нааш судлаачдын анхаарлыг татсаар иржээ. 3000 гаруй жилийн тэртээд өнөөгийн Монгол нутагт оршин амьдарч байсан нүүдэлчдийн нийгэм, соёлын томоохон ул мөрийг илтгэн харуулдаг энэхүү дурсгалын тархалт нь өнөөгийн Монгол улсын төв, умард, баруун бүс нутгаар төвлөрөн хил залгаа ОХУ-ны Буриад, Тува, Алтай, Казахстан, БНХАУ-ын Шинжаан-Уйгурын өөртөө засах орны нутагт хүртэл маш өргөн газар нутгийг хамардаг. Уг соёлын хүрээнд хамаарах ижил төстэй чулуун хөшөөд бүр Хар далай, Кавказын уулс, Эльба мөрний сав газар хүртэл бүртгэгджээ. Монгол улсын нутагт 2017 оны байдлаар нийт 1300 орчим, хил залгаа бүс нутагт 200 гаруй буган хөшөө бүртгэгдээд байсан (Баярсайхан 2017, 23) бол энэ тоо жил ирэх тусам нэмэгдсээр байна.

Энэхүү өгүүлэлд 2022-2023 онд Хөвсгөл аймгийн зарим сумдын нутгаас шинээр илрүүлэн бүртгэж, баримтжуулсан буган хөшөөдийн тухай авч үзлээ. Буган хөшөө-хиргисүүрийн соёл"-ын тархалтын умард бүс нутагт хамаарах Хөвсгөл аймгийн Арбулаг, Алаг-Эрдэнэ, Их-Уул, Мөрөн, Тосонцэнгэл, Түнэл сумдын нутагт 1960-аад оноос өнөөг хүртэл нийтдээ 25 дурсгалт газар 55 буган хөшөө бүртгэгджээ. Эдгээрийн дотор бидний сүүлийн гурван жилийн хугацаанд шинээр илрүүлсэн 11 дурсгалт газрын 30 буган хөшөө багтаж байгаа бөгөөд энэ нь урьд өмнө судалгааны эргэлтэд ороогүй дурсгалууд юм. Энэхүү өгүүлэлд шинээр илрүүлсэн гучин буган хөшөөний талаарх анхан шатны судалгааны үр дүнг танилцуулж байна.

Дурсгалт газар болон буган хөшөөдийн тодорхойлолт

Алтангадас уулын буган хөшөө. Хөвсгөл аймгийн Арбулаг сумын нутаг Дэлгэрмөрөний хойд хөвөөн дэх “Мөнх хаан”-ы балгасын зүүнтээ байх өнчин ганц хадтай уулыг Алтангадас уул хэмээн нэрлэдэг. Энэ уулын зүүн хойно холгүй зайд хугархай буган хөшөө, түүнээс холгүй дугуй чулуун дараастай булш буйг 2022 онд бүртгэн, баримтжуулав (Баярсайхан, Хүрэлсүх 2022).

Буган хөшөөний тодорхойлолт: Саарал боржин чулуугаар хийсэн уг хөшөөний өндөр 141 см, өргөн 20 см, зузаан 53 см. Уг буган хөшөөний дээд хэсэг хугарч алга болсон. Хөшөөний нүүрэн талд хоёр салаа дэгээ, нэг бугын гуя, баруун хажууд дөрвөн буга дүрсэлсний хамгийн доод талын бугын толгойг доош ташуу хандуулан дүрсэлсэн бол бусад бугыг дээш цоройлгон дүрсэлж, доод талын бугын хүзүүн дор байлдааны сүх сийлжээ. Зүүн

хажууд хоёр бугыг толгойгоор нь доош хандуулан сийлээд, тэдгээрийн дор цагариган балтагтай, хуйтай чинжаал, дугуй толь, нум сум, цагаригласан араатан амьтан тус тус дүрсэлжээ (Зураг 1-А). Уг хөшөө нь бугын хийсвэр дүрслэлтэй буган хөшөөний ангилалд багтана. Хадгалалтын байдал дунд зэрэг. Дээд хэсэг хугарч үгүй болсон.

Төгөл модны буган хөшөөд. Хөвсгөл аймгийн Алаг-Эрдэнэ сумын төвөөс зүүн тийш 20 орчим км Чулуутын Төгөл мод хэмээх зуслангийн нутагт газарт унасан буган хөшөө буйг 2023 оны зун бүртгэн баримтжуулав (Эрэгзэн нар, 2023).

1 дүгээр буган хөшөө: Саарал өнгийн боржин чулуугаар хийсэн уг хөшөөний өндөр 146 см, зузаан 49 см, өргөн 26 см. Хөшөөний нүүрэн талд хос ташуу зураастай, зүүн дээд талд нь дугуй унжлагатай цагариг ээмэг, баруун дээд талд нь энгийн цагариг ээмэг сийлж, тэдгээрийн доогуур хөшөөг тойруулан жижиг зууван хонхрууд сийлж хүзүүний зүүлтийг илэрхийлжээ. Хөшөөний дунд хэсгийг бүслүүрдэн шулуун ховилоор бүс сийлж, зүүн ташаанд бүснээс чинжаал, жижиг хутга, нум зүүснээр тус тус дүрсэлжээ (Зураг 1-Б). Амьтны дүрслэлгүй буган хөшөөний ангилалд багтана. Хадгалалтын байдал сайн.

2 дугаар буган хөшөө: Саарал өнгийн боржин чулуугаар хийсэн уг хөшөөний өндөр 100 см, зузаан 36 см, өргөн 18 см. Хөшөөний нүүрэн талд гурван ташуу зураас, түүний зэрэгцээ зүүн хажуугийн дээд хэсэгт цагариг ээмэг сийлж, тэдгээрийн доогуур хөшөөг тойруулан жижиг дугуй хонхрууд гаргаж, хүзүүний зүүлтийг илэрхийлжээ. Хөшөөний дунд хэсгийг бүслүүрдэн нарийн ховилоор бүс сийлж, зүүн талд бүснээс дугуй цагариг толттой, чагтан балтагтай чинжаал болон жижиг хутга, хормсоготой нум зэргийг тус тус зүүснээр дүрсэлжээ. Ар талд бүсний дээд талд тагнай хээтэй таван талт бамбай мөн сийлсэн байна (Зураг 1-В). Амьтны дүрслэлгүй буган хөшөөний ангилалд багтана. Хадгалалтын байдал сайн.

3 дугаар буган хөшөө: Саарал өнгийн боржин чулуугаар хийсэн уг хөшөөний өндөр 141 см, зузаан 46 см, өргөн 22 см. Уг хөшөөний нүүрэн талын дээд хэсэгт жижиг дугуй дүрс, гурван ташуу зураас, түүний зэрэгцээ зүүн хажуу талд унжлагатай цагариг ээмэг, баруун хажууд дундаа дугуй хонхортой унжлагатай цагариг ээмэг сийлж, тэдгээрийн доогуур хөшөөг тойруулан жижиг дугуй хонхрууд гаргаж, хүзүүний зүүлтийг илэрхийлжээ. Түүнээс доош нүүрэн талд нэг бугын толгой эврийн хараа, баруун талд нүүрэн талын бугын хоёр салаа эвэр, нар зөв тав эргэсэн ороомог дүрс, ар талд тагнай хээтэй таван талт бамбай дүрсэлжээ. Эдгээрийн доогуур хөшөөг бүслүүрдэн шулуун ховилоор бүс сийлж, нүүрэн талд бүсний дор цагариг толттой жижиг хутга тус

тус сийлжээ (Зураг 1-Г). Бугын хийсвэр дүрслэлтэй буган хөшөөний ангилалд багтана. Хадгалалтын байдал сайн.

Бугатын буган хөшөө. Уг дурсгалт газар нь Хөвсгөл аймгийн Тосонцэнгэл сумын нутаг Бугат хэмээх газар байх ба нийт таван буган хөшөө, найман дугуй чулуун овоолго бүхий тахилгын байгууламж, зургаан цагариг хэлбэрийн тахилгын байгууламжаас бүрдэнэ. Харамсалтай нь эдгээр буган хөшөөдийг нутгийн нэгэн малчин анхны байрнаас зөөж, өвөлжөөний чулуун хороонд ашигласан байсныг сумын соёлын төвийн ажилтнууд мэдэж, улмаар Хөвсгөл аймгийн ЗДТГ-ын Соёл, урлагийн газраас шаардлага хүргүүлсний үр дүнд хөшөөдийг байсан газарт нь буцаан тавьжээ. Энэхүү балмад үйл явдлаас болж зарим хөшөө гэмтэж, зарим хөшөөнд их хэмжээний цементэн зуурмаг наалдаж бохирджээ (Эрэгзэн нар, 2023).

1 дүгээр буган хөшөө: Саарал өнгийн боржин чулуугаар хийсэн уг хөшөөний өндөр 79 см, зузаан 41 см, өргөн 28 см. Уг хөшөөний нүүрэн талын дээд хэсэгт хоёр ташуу зураас, түүний зэрэгцээ баруун хажууд цагариг ээмэг сийлж, тэдгээрийн доогуур хөшөөг тойруулан жижиг дугуй хонхрууд гаргаж, хүзүүний зүүлтийг илэрхийлжээ. Хөшөөний дундаас доохнуур бүслүүрдэн шулуун ховилоор бүс сийлж, зүүн хажууд бүснээс трапец хэлбэрийн хавтага маягийн эд зүйлс зүүснээр дүрсэлжээ (Зураг 1-Д). Амьтны дүрслэлгүй буган хөшөөний ангилалд багтана. Хадгалалтын байдал сайн.

2 дугаар буган хөшөө: Саарал өнгийн боржин чулуугаар хийсэн уг хөшөөний өндөр 79 см, зузаан 33 см, өргөн 16 см. Уг хөшөөний нүүрэн талын дээд хэсэгт хоёр ташуу зураас, түүний зэрэгцээ баруун талд цагариг ээмэг, зүүн хажуу талд үрлэн унжлагатай цагариг ээмэг, тэдгээрийн доогуур хөшөөг тойруулан жижиг хонхруудаар хүзүүний зүүлт дүрсэлжээ. Хүзүүний зүүлтээс доош нүүрэн талд дугуй толь, зүүн хажууд тагнай хээтэй таван талт бамбай, хөшөөний дундаас доохнуур өргөн цулгүй бүс, бүснээс нүүрэн талд дугуй толттой, чагтан балтагтай чинжаал, баруун хажууд сүх, зүүн хажууд билүү чулуу, трапец хэлбэрийн хавтага бололтой эд зүйл, хоромсоготой нум зэргийг тус тус зүүснээр дүрсэлсэн байна (Зураг 1-Е). Амьтны дүрслэлгүй буган хөшөөний ангилалд багтана. Хадгалалтын байдал дунд зэрэг. Хөшөөний зарим сийлбэрүүд ховхорч гэмтсэн. Зарим талбайд цемент наалдсан.

3 дугаар буган хөшөө: Саарал өнгийн боржин чулуугаар хийсэн уг хөшөөний өндөр 125 см, зузаан 54 см, өргөн 14 см. Уг хөшөөний нүүрэн талын дээд хэсэгт хоёр ташуу зураас, түүний зэрэгцээ баруун талд цагариг ээмэг, зүүн хажуу талд үрлэн унжлагатай цагариг ээмэг, тэдгээрийн

доогуур хөшөөг тойруулан жижиг хонхруудаар хүзүүний зүүлт дүрсэлжээ. Хүзүүний зүүлтээс доош баруун хажууд дугуй толь, түүний доогуур хөшөөг тойруулан цулгүй бүс, бүснээс баруун хажууд билүү чулуу бололтой нэг жижиг гонзгой зүйл зүүснээр сийлжээ. Түүний хажууд бас нэг урт гонзгой эд зүйлийн нэг хэсэг хадгалагдаж үлдсэн боловч нөгөө хэсэг нь хугарч алга болжээ (Зураг 1-Ё). Амьтны дүрслэлгүй буган хөшөөний ангилалд багтана. Хадгалалтын байдал дунд зэрэг. Доод хэсгээрээ хугарч, ёроол хэсэг алга болсон.

4 дүгээр буган хөшөө: Саарал өнгийн боржин чулуугаар хийсэн уг хөшөөний өндөр 107 см, зузаан 29 см, өргөн 26 см. Уг хөшөөний нүүрэн талын дээд хэсэгт хоёр ташуу зураас, түүний зэрэгцээ баруун талд үрлэн унжлагатай цагариг ээмэг дүрсэлжээ. Мөн хөшөөний дунд хэсэгт цулгүй шулуун бүс сийлжээ (Зураг 1-Ж). Амьтны дүрслэлгүй буган хөшөөний ангилалд багтана. Хадгалалтын байдал дунд зэрэг.

5 дугаар буган хөшөө: Саарал өнгийн чулуугаар хийсэн уг хөшөөний өндөр 97 см, зузаан 50 см, өргөн 16 см. Уг хөшөөний нүүрэн талын дээд хэсэгт хоёр ташуу зураас, түүний доогуур хөшөөг тойруулан жижиг хонхруудаар хүзүүний зүүлт дүрсэлжээ. Дунд хэсэгт цулгүй шулуун бүс сийлжээ. Нүүрэн талд бүсний дээхэн талд дугуй толь хонхойлгон сийлсэн. Уг хөшөөний баруун хажуу талын сийлбэр дүрслэлүүд цементэд хучигдсаны улмаас мэдэгдэх зүйлгүй болсон (Зураг 1-З). Амьтны дүрслэлгүй буган хөшөөний ангилалд багтана. Хадгалалтын байдал муу. Хөшөөний баруун хажуу тал бүхэлдээ, зүүн хажуу тал хэсэгчлэн цементээр хучигдсан.

Шивээтийн буган хөшөө. Хөвсгөл аймгийн Их-Уул сумын нутаг Шивээт хэмээх газар 37х33.5 м дөрвөлжин хүрээтэй, голдоо 17м голчтой дугуй овоолго бүхий хиргисүүрийн зүүн талд газарт унасан буган хөшөө байна. Уг дурсгал болон Сантын овоо-1,2, Цахир толгойн дурсгалт газруудыг 2023 онд Их-Уул сумын Соёлын төвийн эрхлэгчээр ажиллаж байсан Лувсангармаагийн Даваанямын мэдээллийн дагуу очиж, бүртгэн баримтжуулсан билээ (Эрэгзэн нар, 2023).

Буган хөшөөний тодорхойлолт: Бор шаргалдуу өнгөтэй боржин бололтой чулуугаар хийсэн уг буган хөшөөний өндөр 195 см, зузаан 62 см, өргөн 20 см. Хөшөөний нүүрэн талын дээд хэсэгт нэг эгнээ 6 ширхэг зууван дугуй дүрсний дор гурван ширхэг дугуй хонхорхойг ташуу байдлаар сийлж, тэдгээрийн зэрэгцээ зүүн хажууд унжлагатай цагариг ээмэг, тэдгээрийн доогуур хөшөөг тойруулан хөрөөний ир шиг иржгэр унжлагатай хүзүүний зүүлт, нүүрэн талд хүзүүний зүүлтээс том амьтны (гахайн) соёо зүүснээр дүрсэлжээ. Хөшөөний дундаас доохнуур цулгүй бүс, бүснээс эргэн тойрон 12 ширхэг агсарга унжлага зүүснээр

тус тус сийлжээ (Зураг 2-А). Уг хөшөө нь амьтны дүрслэлгүй буган хөшөөний ангилалд багтана. Хадгалалтын байдал дунд зэрэг.

Цахир толгойн буган хөшөөд. Хөвсгөл аймгийн Их-Уул сумын нутаг Мөнгөн уулын урд бэл жижиг дэвсгэ толгойг Цахир толгой хэмээн нэрлэнэ. Энэ толгойн орой тэгш дэвсгэ дээр дөрвөлжин болон дугуй хүрээтэй хоёр жижгэвтэр хиргисүүрийн зүүнтээ ухсан нүхэн дотор нэг, нүхний зүүн талд бас нэг буган хөшөө хэвтэж байв. Нутгийн хүмүүсийн ярих нь нүхэн дотор буй буган хөшөө босоо байсан боловч сүүлд хүмүүс нууцаар ухаад, хөшөөг унагасан гэх.

1 дүгээр буган хөшөө: Саарал боржин чулуугаар хийсэн уг буган хөшөөний өндөр 223 см, зузаан 42 см, өргөн 24 см. Уг хөшөөний баруун хажуу талын дээд хэсэгт унжлагатай цагариг ээмэг, түүний эсрэг зүүн хажуу дээд талд том, жижиг хоёр цагариг, тэдгээрийн доогуур хөшөөг тойруулан дөрвөлжин нүд бүхий хүзүүний зүүлт сийлээд, нүүрэн талд зүүлтээс амьтны соёо (гахай) хэлбэртэй сондор зүүснээр дүрсэлжээ. Түүнээс доош бүс хүртэлх зайд зүүн хажууд хоёр дугуй толь, хөвчилсөн нум сум сийлсэн. Дунд хэсгээр уулан хээтэй өргөн бүс тойруулан урлаж, бүснээс нүүрэн талд хутга, баруун хажууд байлдааны зээтүү, хоромсого, зүүн хажууд дугуй толттой, чагтан балтагтай чинжаал тус тус зүүж дүрсэлжээ (Зураг 2-Б). Уг хөшөө нь амьтны дүрслэлгүй буган хөшөөний ангилалд багтана. Хадгалалтын байдал дунд зэрэг.

2 дугаар буган хөшөө: Саарал боржин чулуугаар хийсэн уг буган хөшөөний өндөр 150 см, зузаан 28 см, өргөн 28 см. Уг хөшөө нь 1 дүгээр буган хөшөөнөөс хойш холгүй зайд газар унасан байв. Хөшөөний гадаргуу бүсний дүрслэлийн хэсэг болов уу гэмээр нэг жижиг хонхор ховилын хэсгээс өөр сийлбэр мэдэгдэхгүй байна (Зураг 2-В). Уг хөшөө нь амьтны дүрслэлгүй буган хөшөөний ангилалд багтана. Хадгалалтын байдал дунд.

Сантын овоо- 1 дурсгалт газрын буган хөшөөд. Хөвсгөл аймгийн Их-Уул сумын нутаг Халзан бүргэдэй уул болон Мөнгөний уулын завсар байх овоот толгойг Сантын овоо гэж нэрлэнэ. Сантын овооны арын хөндийд буй дугуй хүрээтэй том хиргисүүрээс урагш холгүй зайд ухсан бололтой хонхордуу газрын хажууд гурван буган хөшөө газарт сул хэвтэж байна. Ойр хавьд нь ямар нэгэн тахилгын байгууламж, чулуун байгууламжгүй.

1 дүгээр буган хөшөө: Саарал боржин чулуугаар хийсэн уг хөшөөний өндөр 158 см, зузаан 34 см, өргөн 19 см. Уг хөшөөний нүүрэн талын дээд хэсэгт гурван ташуу зураас сийлж, түүний зэрэгцээ зүүн хажууд цагариг ээмэг, баруун хажууд унжлагатай цагариг ээмэг болон бас нэг жижиг цагариг дүрсэлжээ. Унжлагатай цагариг ээмэгний дүрсний

зарим хэсэг ховхорч үгүй болсон. Тэдгээрийн доогуур хөшөөг тойруулан нарийн ховилоор хүзүүний зүүлтийг илэрхийлжээ. Хөшөөний дунд хэсэгт нарийн ховил шулуун бүс гаргаж, нүүрэн талд гүйвэр зэвсгийг бүсэнд хавчуулж, зүүн хажууд хутга болов уу гэмээр хоёр гонзгой зүйлийг бүснээс зүүснээр тус тус сийлжээ (Зураг 2-Г). Уг хөшөө нь амьтны дүрслэлгүй буган хөшөөний ангилалд багтана. Хадгалалтын байдал дунд.

2 дугаар буган хөшөө: Саарал боржин чулуугаар хийсэн эл буган хөшөөний өндөр 93 см, зузаан 30 см, өргөн 19 см. Уг хөшөөний баруун болон зүүн хажуу талын дээд хэсэгт нэжгээд цагариг ээмэг дүрсэлж, дунд хэсэгт хөшөөг тойруулан нарийн ховилоор бүс сийлсэн (Зураг 2-Д). Уг хөшөө нь амьтны дүрслэлгүй буган хөшөөний ангилалд багтана. Хадгалалтын байдал дунд.

3 дугаар буган хөшөө: Саарал боржин чулуугаар хийсэн эл буган хөшөөний өндөр 182 см, зузаан 40 см, өргөн 39 см. Уг хөшөөний нүүрэн талын дээд хэсэгт гурван ташуу зураас, түүний харалдаа зүүн хажууд үрлэн унжлагатай цагариг ээмэг, баруун хажууд том, жижиг хоёр цагариг ээмэг, тэдгээрийн доогуур зууван дугуй хонхруудаар хүзүүний зүүлтийг илэрхийлжээ. Хөшөөний дунд хэсэгт шулуун ховилоор бүс сийлж, зүүн хажуу талд бүсэнд хоромсоготой нум хавчуулж, түүний дээхэн талд дугуй толь тус тус дүрсэлжээ (Зураг 2-Е). Уг хөшөө нь амьтны дүрслэлгүй буган хөшөөний ангилалд багтана. Хадгалалтын байдал дунд.

Сантын овоо-2 дурсгалт газрын буган хөшөөд. Сантын овоо-1 дурсгалт газраас хойш дугуй хүрээтэй том хиргисүүрээс холгүй зүүн талд тахилгын байгууламжуудынхаа хажууд, анхны байрлал дээрээ унасан хоёр буган хөшөө, хиргисүүрийн хүрэн дотор голын чулуун овоолгын зүүн урд талд бас нэг буган хөшөө газарт унаж, хагас булагдсан байдалтай байна. Өөр хоорондоо холгүй зайд байх эдгээр гурван буган хөшөөг бид Сантын овоо-2 хэмээн дугаарлаж, бүртгэн баримтжуулав.

1 дүгээр буган хөшөө: Саарал боржин чулуугаар хийсэн уг хөшөөний өндөр 187 см, зузаан 36 см, өргөн 36 см. Уг хөшөөний нүүрэн талын дээд хэсэгт хоёр ташуу зураас, түүний харалдаа зүүн болон баруун хажууд нэжгээд цагариг ээмэг, хөшөөний дунд хэсэгт шулуун ховилоор бүс сийлж, бүснээс нүүрэн талд дугуй толттой, чагтан балтагтай хутга, баруун хажууд байлдааны зээтүү тус тус зүүж дүрсэлжээ (Зураг 2-Ё). Уг хөшөө нь амьтны дүрслэлгүй буган хөшөөний ангилалд багтана. Хадгалалтын байдал дунд.

2 дугаар буган хөшөө: Саарал боржин чулуугаар хийсэн уг буган хөшөөний өндөр 158 см, зузаан 24 см, өргөн 22 см. Уг хөшөө нь дугуй хүрээтэй том хиргисүүрээс зүүн тийш баруун хажуу талын

дээд хэсэгт цагариг ээмэг, дунд хэсэгт шулуун ховилоор бүс сийлж, бүснээс нүүрэн талд дугуй толттой, чагтан балтагтай хутга, баруун хажууд байлдааны зээтүү, зүүн хажууд хоромсоготой нум тус тус зүүж дүрсэлжээ (Зураг 2-Ж). Уг хөшөө нь амьтны дүрслэлгүй буган хөшөөний ангилалд багтана. Хадгалалтын байдал дунд.

3 дугаар буган хөшөө: Саарал боржин чулуугаар хийсэн уг буган хөшөөний өндөр 102 см, зузаан 38 см, өргөн 29 см. Уг хөшөө нь том дугуй хиргисүүрийн голын чулуун овоолгын зүүн талд анхны байрлал дээрээ унаж, газарт хагас булагдсан байдалтай байв. Хөшөөний орой хэсгийг тойруулан урд талдаа дугуй сэртэнтэй өргөн ховилоор толгойн боолт (титэм), түүний дор зүүн хажууд үрлэн унжлагатай цагариг ээмэг, баруун хажууд цагариг ээмэг, тэдгээрийн доогуур зууван дугуй хонхруудаар хүзүүний зүүлтийг тус тус сийлжээ. Зүүн хажууд ээмэгний хажууд бас нэгэн жижиг дугуй хонхор сийлбэр байна (Зураг 2-З). Уг хөшөө нь амьтны дүрслэлгүй буган хөшөөний ангилалд багтана. Хадгалалтын байдал сайн.

Яргайтын амны буган хөшөөд. Хөвсгөл аймгийн Түнэл сумын төвөөс хойш 15 км зайд Эгийн голын хойд бие Яргайтын ам хэмээх газар хоёр буган хөшөө байна. Энд хажуу тийшээ налж хазайсан нэг хөшөө байсныг Түнэл сумын Засаг даргын орлогч Ж.Самбаллхүндэв үзэж, гэрэл зургийг археологич Ж.Баярсайханд илгээснээр 2021 онд судалгааны баг очиж, буган хөшөө болохыг тогтоожээ (Баярсайхан нар, 2021). Хөшөөний налуу байдлаас харахад нүүрэн тал нь хойд зүг рүү харж байсан бололтой. Тиймээс хөшөөний анхны зүг чиг алдагдаж, хожим нэгэн цагт хөшөөг буруу харуулан босгосон аж. Үүнтэй холбоотой нэгэн аман мэдээг Түнэл сумын орлогч дарга Ж.Самбаллхүндэв бидэнд өгсөн юм. Тэрээр нутгийн хөгшчүүл хөшөө чулууг хаа нэг газар нэгэн нууц эрдэнэсийн зүг чигийг зааж байсныг цаатай улсууд ирээд юмыг нь олж аваад зүгийг нь буруу харуулсан юм гэнэлээ гэж ярьдаг байсан хэмээн хуучилсан. Бид дурсгалт газарт дээрх буган хөшөөний урд талаас газарт унасан бас нэг буган хөшөөг илрүүлэн олсон билээ. Эдгээр хөшөөдийн эргэн тойронд тахилгын байгууламжууд буйгаас харахад хэдийгээр налж хазайсан, унасан боловч анхны байрлал дээрээ буй нь илэрхий мэдэгдэж байна.

1 дүгээр буган хөшөө: Уг хөшөөг мөн саарал боржин чулуугаар хийжээ. Хөшөөний өндөр нь 125 см, зузаан нь 35 см, өргөн нь 20 см. Хөшөөний нүүрэн талын дээд хэсэгт хоёр ташуу зураас дүрсэлж, түүний доогуур хөшөөг тойруулан 15 ширхэг хонхор дүрсээр хүзүүний зүүлтийг илэрхийлжээ. Түүнээс доош бүс хүртэлх зайд баруун хажууд дугуй цагариган дүрстэй толь

дүрсэлж, хөшөөний дундаас доохнуур цулгуй нарийн ховилоор бүс сийлж, баруун хажууд бүсний дор хутга болов уу гэмээр урт гонзгой дүрс тус тус сийлжээ (Зураг 3-А). Уг хөшөө нь амьтны дүрслэлгүй буган хөшөөний ангилалд багтана. Хадгалалтын байдал сайн.

2 дугаар буган хөшөө: Уг хөшөөг хөх саарал боржин чулуугаар хийсэн бөгөөд хажуу тийшээ хазайсан налуу байдалтай байна. Хөшөө газраас дээш орой хүртэл 185 см өндөр, 45 см өргөн, 28 см зузаан. Нүүрэн талын дээд хэсэгт хоёр ташуу зураас түүний зэрэгцээ баруун хажууд доороо үрлэн унжлагатай цагариг ээмэг сийлж, тэдгээрийн доогуур хөшөөг тойруулан 16 ширхэг зууван дугуй хонхруудаар хүзүүний зүүлтийг дүрсэлжээ. Үүнээс доош бүс хүртэлх зайд нүүрэн талд дугуй цагаригаар толь, зүүн хажууд тагнай хээтэй таван талт бамбай дүрсэлж, хөшөөний доод хэсгээр цулгуй шулуун ховилоор бүс, бүснээс нүүрэн талд дугуй толттой, чагтан балтагтай том чинжаал хутга зүүснээр тус тус сийлжээ (Зураг 3-Б). Уг хөшөө нь амьтны дүрслэлгүй буган хөшөөний ангилалд багтана. Хадгалалтын байдал сайн.

Сахалтын амны буган хөшөөд. Түнэл сумын төвөөс баруун хойш 32 км зайд Сахалтын ам хэмээх газар урьд өмнө судалгаанд хамрагдаагүй нэгэн чухал дурсгалт газар байсныг нутгийн хүмүүс эртнээс хайрлан хамгаалж иржээ. Энэ дурсгалт газрын тухай анх Алаг-Эрдэнэ сумын Тамгын газрын дарга, аймгийн начин Ё.Даваа, археологич Ж.Баярсайханд мэдээлжээ. Энэ мэдээллийн дагуу судалгааны баг 2021 онд Түнэл сумын орлогч дарга Ж.Самбаллхүндэвээр газарчлуулан дурсгалт газарт очиж, нийт 160 орчим хиргисүүр, булш, 20 орчим Түрэгийн тахилгын онгон бүхий томоохон цогцолбор буйг бүртгэж, анхан шатны баримтжуулалт хийсэн юм. Мөн буган хөшөө байж болохуйц хэд хэдэн газарт нягтлан шалгаж, нийтдээ 5 буган хөшөөг шинээр илрүүлэн олов. Эдгээр буган хөшөөний 3 нь (буган хөшөө №1-3) хожим Түрэгийн тахилгын онгоны хашлага, зэл чулуунд ашиглагджээ. Харин хоёр нь (буган хөшөө №4-5) дурсгалт газрын зүүн урд хэсэгт байрлах 63 м дугуй хүрээтэй, 38 м голчтой чулуун овоолго бүхий хиргисүүрийн зүүн хажууд хүрээний гадна талд зүүн болон зүүн хойд талд анхны байрлалдаа унасан байв. Үүний нэг нь (буган хөшөө №4) хиргисүүрийн хүрээ болон тахилгын байгууламжуудын завсар дахь зайд байгаа бол нөгөөх нь (буган хөшөө №5) хиргисүүрийн хүрээнээс 25 м орчим зайд дугуй чулуун овоолго бүхий 1 дүгээр хэлбэрийн тахилгын байгууламжуудаас гадагш дугуй цагариг хэлбэрийн тахилгын байгууламжуудаас дотогш зайд байрлаж байна. Эхний гурван буган хөшөөний хойд талд 70 гаруй метрийн зайд 55 м голчтой дугуй хүрээтэй 28 м голчтой дугуй чулуун дараастай, хүрээний

гадна зүүн урд талдаа 13 ширхэг, баруун хойд талдаа 3 ширхэг буюу нийт 16 ширхэг дугуй чулуун дараастай тахилгын байгууламжтай, түүний гадуур эргэн тойрон олон жижиг цагариг тахилгын байгууламжтай нэгэн хиргисүүр бий. Эдгээр буган хөшөөдийг дурдсан хиргисүүр болон Түрэгийн тахилгын онгонуудын баруун талд буй буган хөшөө байсан бололтой 2-3 бүлэг тахилгын байгууламжуудаас зөөн авчирсан бололтой (Баярсайхан нар, 2021).

1 дүгээр буган хөшөө: Энэ хөшөө цувраа дөрвөн Түрэгийн тахилгын онгоны урдаасаа хоёр дахь тахилгын байгууламжийн зүүн талд эхний зэл чулуу болгон ашигласан. Газраас дээш цухуйж буй өндөр нь 24 см, өргөн нь 24 см, зузаан нь 31 см. Уг хөшөөний зүүн хажууд цагариг ээмэг сийлсний тал хэсэг нь газарт булагдан зөвхөн тал хэсэг нь ил харагдаж байна (Зураг 3-В). Уг хөшөө нь амьтны дүрслэлгүй буган хөшөөний ангилалд багтана. Хадгалалтын байдал дунд.

2 дугаар буган хөшөө: Уг хөшөөг хөх саарал боржин чулуугаар хийсэн бөгөөд 1 дүгээр буган хөшөөний зүүн хажууд буюу дээр дурдсан Түрэгийн тахилгын онгоны хоёр дахь зэл чулуу болгон дахин ашиглажээ. 27 см өндөр. Хөшөөний нүүрэн талыг баруун тийш харуулан босгосон бөгөөд тэр тал дээр хоёр ташуу зураас түүний зэрэгцээ хөшөөний зүүн хажуу талд /өнөөгийн байрлалаар бол урд тал Ж.Б/ дугуй цагариг ээмэг тус тус сийлсэн нь газраас дээш ил буй талуудад харагдаж байна (Зураг 3-Г). Уг хөшөө нь амьтны дүрслэлгүй буган хөшөөний ангилалд багтана. Хадгалалтын байдал дунд. Уг хөшөө нь амьтны дүрслэлгүй буган хөшөөний ангилалд багтана. Хадгалалтын байдал дунд.

3 дугаар буган хөшөө: Уг хөшөө нь өмнөх хоёр хөшөөг ашигласан Түрэгийн тахилгын онгоны хойд талын тахилгын онгоны баруун хойд буланд хашлага болгон ашигласан байна. Саарал боржин чулуугаар хийсэн уг хөшөөний зөвхөн нэг талын багахан хэсэг нь ил харагдах бөгөөд бусад хэсэг нь газарт булагджээ. Ил харагдаж буй гадаргуу дээр дугуй хонхруудаар хүзүүний зүүлт сийлсэн нь тодорхой харагдах бөгөөд эдгээрээс нэг хонхрыг бусдаас нь илүү томоор дүрсэлсэн нь амьтны дүрслэлгүй буган хөшөөний хүзүүний зүүлтийн ар шилэн хүзүүн дээрх нэг сувсыг бусдаас илүү томоор дүрсэлсэн байдагтай адил байна (Зураг 3-Д). Уг хөшөө нь амьтны дүрслэлгүй буган хөшөөний ангилалд багтана. Хадгалалтын байдал дунд.

4 дүгээр буган хөшөө: Эл хөшөөг саарал боржин чулуугаар хийсэн бөгөөд 131 см өндөр, 30 см өргөн, 34 см зузаан. Хөшөөний нүүрэн талын дээд хэсэгт 2 ташуу зураас, түүний зэрэгцээ баруун хажууд цагариг ээмэг тэдгээрээс доош зүүн хажууд талд дугуй толь сийлж, хөшөөний тэг

дундуур шулуун ховилоор бүс, бүснээс баруун хажууд байлдааны сүх, зүүн хажууд хутга, нум тус тус зүүснээр дүрсэлжээ (Зураг 3-Е). Уг хөшөө нь амьтны дүрслэлгүй буган хөшөөний ангилалд багтана. Хадгалалтын байдал дунд.

5 дугаар буган хөшөө: Эл хөшөөг цагаан саарал боржин чулуугаар хийсэн 145 см өндөр, 43 см өргөн, 27 см зузаан. Хөшөөний нүүрэн талын дээд хэсэгт хоёр ташуу зураас, түүнээс доош дунд хэсэгт шулуун ховилоор бүс дүрсэлж, бүснээс баруун хажууд байлдааны сүх, зүүн хажууд чагтан балтагтай бөгтөрдүү хутга, хоромсоготой нум зүүснээр тус тус дүрсэлжээ (зураг 3-Ё). Уг хөшөө нь амьтны дүрслэлгүй буган хөшөөний ангилалд багтана. Хадгалалтын байдал дунд.

Цагаан толгой-1 дурсгалт газрын буган хөшөөд. Түнэл сумын төвөөс баруун урд зүгт шулуунаар 9 км орчим зайд зуслангийн нутаг Цагаан толгой хэмээх газарт 2022 оны зун бид санамсаргүй байдлаар дөрвөн буган хөшөөг илрүүлсэн бөгөөд эдгээрийн нэг нь буюу ээмэгний дүрслэл бүхий буган хөшөөний хугархайг Цагаан толгойн зуслангийн адууны хашааны орчмоос олж илрүүлэн, тэндээс холгүй урд талын дэнж дээрээс өөр гурван буган хөшөөг нутгийн иргэдийн мэдээллээр илрүүлэн баримтжуулсан билээ (Эрэгзэн нар, 2022). Эдгээр гурван буган хөшөөний хамгийн том нь анхны байрлал дээрээ тахилгын байгууламж дундаа унасан байдалтай байгаа бол нөгөө хоёр нь холгүй дөрвөлжин хэлбэртэй болгон өрсөн чулуунуудын дунд байв.

1 дүгээр буган хөшөө: Саарал боржин чулуугаар хийсэн уг хөшөөний өндөр 128 см, өргөн 18 см, зузаан 25 см. Хөшөөний нүүрэн талын дээд хэсэгт хоёр ташуу зураас, түүний зэрэгцээ баруун хажуу талд дороо үрлэн унжлагатай цагариг ээмэг, зүүн хажуу талд цагариг ээмэг, түүнээс доош ар талд тагнай хээтэй таван талт бамбай, түүний доогуур шулуун ховилоор бүс дүрсэлж, бүснээс баруун хажууд сүх, зүүн хажууд хоромсоготой нум тус тус зүүснээр сийлжээ (Зураг 4-А). Уг хөшөө нь амьтны дүрслэлгүй буган хөшөөний ангилалд багтана. Хадгалалтын байдал муу, хоёр хэсэг газраар хугарч, гурван хэсэг болон хугарсан.

2 дугаар буган хөшөө: Саарал боржин чулуугаар хийсэн эл хөшөөний өндөр 109 см, өргөн 20 см, 30 см. Хөшөөний нүүрэн талд гурван ташуу зураас, түүний зэрэгцээ баруун хажууд цагариг ээмэг, зүүн талд доороо үрлэн унжлагатай цагариг ээмэг, тэдгээрийн доогуур олон жижиг хонхруудаар хүзүүний зүүлт, түүний доор баруун хажуу талд нар зөв эргэлттэй ороомог, зүүн хажууд нумарсан дугуйдуу оройтой тагнай хээтэй бамбай, нүүрэн талд урт сүүлтэй, гурвалжин чихтэй мигүйн төрлийн амьтан, дугуй толь тус тус сийлжээ. Эдгээр дүрслэлийн доогуур шулуун ховилоор бүс дүрсэлж,

бүснээс баруун хажууд байлдааны сүх, зүүн хажууд дугуй толттой, чагтан балтагтай чинжаал, саадаг, нум зүүснээр тус тус урлажээ (Зураг 4-Б). Уг хөшөө нь амьтны бодит дүрслэлтэй буган хөшөөний ангилалд багтана. Хадгалалтын байдал дунд зэрэг.

3 дугаар буган хөшөө: Саарал өнгийн нягт боржин чулуугаар хийсэн эл хөшөөний өндөр 260 см, өргөн 27 см, зузаан 45 см. Хөшөөний орой хэсгийг тойруулан өргөн ховилоор титэм сийлсэн боловч нүүрэн талд босоо товгор шулуун товгор магнайвч маягийн зүйл дүрсэлжээ. Үүний дор нүүрэн талд хоёр ташуу зураас, зэрэгцээ баруун болон зүүн хажууд үрлэн унжлагатай цагариг ээмэг, түүний доогуур олон жижиг хонхруудаар хөшөөг тойруулан хүзүүний зүүлтийг урлан гаргажээ. Үүнээс доош бүс хүртэлх зайд зүүн хажууд голдоо дугуй товруутай, тагнай хээтэй таван талт бамбай, түүний доогуур хөшөөг тойруулан шулуун ховилоор бүс сийлж, бүснээс нүүрэн талд “П” хэлбэрийн дэгээ, баруун хажууд 40 см урт иштэй байлдааны сүх, зүүн хажуу талд хоромсоготой нум, дугуй толттой, чагтан балтагтай 47 см урт чинжаал тус тус зүүснээр уран нарийн дүрсэлжээ (Зураг 4-В). Уг хөшөө нь амьтны дүрслэлгүй буган хөшөөний ангилалд багтана. Хадгалалтын байдал сайн, хуучин суурин дээрээ тахилгын байгууламжуудын дунд унасан байна.

4 дүгээр буган хөшөө: Саарал боржин чулуугаар хийсэн буган хөшөөний орой хэсгийн хугархай. Урт нь 20 см. Нэг талд нь үрлэн унжлагатай цагариг ээмэгний дүрслэлтэй (Зураг 4-Г). Хадгалалтын байдал муу. Хөшөөний бусад хэсэг хугарч алга болсон. Уг хугархай хэсгийг алга болохоос сэргийлж, Түнэл сумын Соёлын төвд тавихаар орон нутгийн захиргааны ажилтнууд авч явсан.

Цагаан толгой-2 дурсгалт газрын буган хөшөө. Уг дурсгалт газар нь Цагаан толгой-1 дурсгалт газраас хойш 1 км орчим зайд, айлын зуслангийн байшингийн урд газарт унаж, хагас булагдсан буган хөшөө буйг 2023 оны хээрийн судалгааны явцад нутгийн иргэний мэдээллийн дагуу очиж, бүртгэн баримтжуулсан билээ (Эрэгзэн нар, 2023).

Буган хөшөөний тодорхойлолт: Цайвар саарал өнгийн боржин чулуугаар хийсэн уг буган хөшөөний өндөр 210 см, өргөн 63 см, зузаан 25 см. Хөшөөний нүүрэн талд гурван ташуу зураас, түүний доогуур олон жижиг хонхруудаар хүзүүний зүүлт сийлсэн боловч баруун болон ар талд дүрслэл нь бүдгэрч мэдэгдэх зүйлгүй болжээ. Дундаас доохнуур шулуун ховилоор бүс дүрсэлсэн боловч зөвхөн урд болох зүүн хажуу талд хагас дутуу хадгалагдаж үлджээ (Зураг 4-Д). Уг хөшөө нь амьтны дүрслэлгүй буган хөшөөний ангилалд багтана. Хадгалалтын байдал муу, хөшөөний баруун болон ар талын сийлбэрүүд элэгдэж гэмтээд мэдэгдэхгүй болжээ.

Судалгааны хэлэлцүүлэг

Монголын умард нутгаас шинээр илрүүлсэн эдгээр гучин буган хөшөөг орос судлаач Н.Н.Диков (1958, 45-46), В.В.Волков (1981, 105) нарын хөгжүүлсэн буган хөшөөний ангилалд тулгуурлан 2017 онд судлаач Ж.Баярсайханы (2017, 71-73) дахин шинэчлэн хөгжүүлсэн дөрвөн ангиллаар хувааж үзвэл 27 нь буюу 90 хувь нь амьтны дүрслэлгүй, 2 нь буюу 7 хувь бугын хийсвэр дүрслэлтэй, 1 нь буюу 3 хувь нь амьтны бодит дүрслэлтэй буган хөшөөний ангилалд багтаж байгаа бол амьтдын холимог дүрслэлтэй буган хөшөө байхгүй байна (Зураг 5). Бугын хийсвэр дүрслэлтэй хоёр хөшөө нь уг хошууны нутгийн баруун бүсэд буюу Уушигийн өвөр, Улаантолгой зэрэг томоохон буган хөшөө, хиргисүүрийн цогцолбор дурсгалын ойролцоох бүс нутагт багтаж байгаа бол бусад хөшөөд нь уг хошууны төв болон умард, зүүн бүс нутагт хамаарч буй юм. Энэ нь уг бүс нутаг буган хөшөө, хиргисүүрийн соёлын тархалтын умард бүс нутгийн онцлогийг харуулж байна.

Буган хөшөө бүхий 11 дурсгалт газрын байршил зүйг ажиглахад Дэлгэрмөрөн, Эгийн гол, Сэлэнгэ зэрэг томоохон гол мөрний савд Алтангадас, Яргайтын ам, Сахалтын ам, Шивээт зэрэг дурсгалт газрууд байгаа бол бусад дурсгалт газрууд нь уулсын завсар дахь жижиг гол, булаг шандтай ойролцоо, дэнж дэвсгэ газруудад байрлаж байна.

Буган хөшөөдийн өнөөгийн оршин байгаа нөхцөл байдлыг судлахад 60 хувь нь буюу 18 хөшөө хиргисүүрээс тусдаа тахилгын байгууламжуудын дэргэд, 13 хувь нь буюу 4 хөшөө хиргисүүрийн овоолгын хажууд эсвэл хүрээний гадна талд, 10 хувь буюу 3 хөшөө Түрэг тахилгын онгонд ашиглагдсан, 17 хувь буюу 5 хөшөө тодорхойлох боломжгүй байршилд тус тус байрлаж байна (Зураг 6).

Буган хөшөөдийн хэмжээний хувьд хамгийн өндөр нь 260 см бөгөөд энэ нь титэм, урт сүх, чинжаал дүрсэлсэн, маш сайн түүхий эдээр хийгдсэн, уран нарийн хийцтэй, тусдаа тахилгын цогцолбор дунд буй Цагаан толгойн 3 дугаар буган хөшөө байна. Хамгийн намхан нь Түрэг тахилгын байгууламжид ашиглагдсан 24 см өндөртэй Сахалтын амны 1 дүгээр буган хөшөө юм. Нийт буган хөшөөдийн дундаж өндрийн хэмжээ нь 127 см аж (Зураг 7).

Дүрслэлийн зарим онцлог: Бидний шинээр илрүүлсэн 30 буган хөшөөний дотор өвөрмөц дүрслэл бүхий хэд хэдэн буган хөшөө буйг энд дурдъя. Юуны түрүүнд титэм буюу толгойн боолт дүрсэлсэн гурван буган хөшөө (Зураг 2-А,3, 4-В) нь маш сайн чулуу сонгож хийсэн төдийгүй Шивээт болон Сантын овоо-2 дурсгалт газрын 3 дугаар буган хөшөө нь хиргисүүрийн хүрэн дотор оршиж

байгаа бол Цагаан толгой –1 дурсгалт газрын 3 дугаар буган хөшөө нь ойр хавьдаа хиргисүүргүй тусдаа тахилгын байгууламжуудын дунд байрлах, төдийгүй хэмжээгээр бусад хөшөөдөөс хамгийн өндөр нь юм. Мөн энэ буган хөшөөнд дүрслэсэн “П” хэлбэрийн дэгээ нь амьтны дүрслэлгүй буган хөшөөнд дүрслэгдсэн 2 дахь тохиолдол бөгөөд бүснээс зүүсэн 47 см урт чичлүүр хутга (илд) нь энэ төрлийн буган хөшөөн дээрх хамгийн урт буюу магадгүй бодит хэмжээгээр дүрслэгдсэн эртний зэвсгийн дүрслэлийн нэг юм. Бугын хийсвэр дүрслэлтэй болон амьтны бодит дүрслэлтэй буган хөшөөнд илд гэж үздэг нэлээд урт хэмжээтэй зэвсгийн хэд хэдэн дүрслэл бий. Эдгээрийн тоонд Баян-Өлгий аймгийн Ногооннуур сумын нутаг Хармагнай буган хөшөөний 98 см урт илд ОХУ-ын Алтайн бүгд найрамдах улсын нутаг Чуй голын буган хөшөөнд 60 см илд (Баяр 1995, 57), Архангай аймгийн Эрдэнэмандал сумын нутаг Донжийн амны буган хөшөө болон Кавказын уулсын бүс дэх 1-2 буган хөшөөнд илд тус тус дүрслэжээ (Даваацэрэн, Анхсанаа 2014, 18-23). Гэхдээ бид дээрх хөшөөн дээрх зэвсгийг хэлбэр, хэмжээгээр нь багцаалж, чичлүүр хутганы төрөл гэж үзэх саналтай байна. Буган хөшөөн дээрх чинжаал буюу чичлүүр хутганы талаар баялаг судалгаа байдаг тул энд дахин нуршихыг үл хүсэв.

Шивээтийн буган хөшөөний титмийг цувраа олон хонхруудаар илэрхийлсэн төдийгүй нүүрэн дээрх гурван ташуу зураасыг гурван хонхор цэгээр сийлсэн нь урьд өмнө буган хөшөөний соёлд огт тохиолдож байгаагүй ховор дүрслэл юм (Зураг 2-А). Мөн Шивээтийн буган хөшөө болон Цахир толгойн 1 дүгээр буган хөшөөний хүзүүний зүүлт нь мөн буган хөшөөний соёлд ховор тохиолдох бөгөөд хоёулаа амьтны (гахай Ж.Б) соёо сондор зүүснээр дүрслэгджээ. Шивээтийн буган хөшөөнд дүрслэгдсэн доороо хөрөөний ир мэт иржгэртэй (амьтны шүдэн Ж.Б) хүзүүний зүүлт үүнээс гадна Уушигийн өврийн 4 болон 7 дугаар буган хөшөөнд хоёр удаа дүрслэгджээ (Баярсайхан 2017, 144-147). Цахир толгойн 1 дүгээр буган хөшөөнд дүрслэгдсэн зэрэгцээ хоёр нарийн ховилыг хооронд нь босоо зураасуудаар холбосон дөрвөлжин нүдтэй хүзүүний зүүлт нь өмнө нь Архангай аймгийн Ихтамир сумын Баянцагааны хөндийн 6 дугаар буган хөшөө, Хайрхан сумын Хөшөөтийн талын 6 дугаар буган хөшөө, Завхан аймгийн Шилүүстэй сумын Дааган дэлийн 2 дугаар буган хөшөө, Баянхонгор аймгийн Гурванбулаг сумын Тэмээн хүзүүний буган хөшөө, Сэлэнгэ аймгийн Хүдэр сумын Хүдэр голын хоёр буган хөшөө зэрэг цөөн тооны буган хөшөөнд тус тус дүрслэгджээ (Волков 2002).

Бидний судалсан эдгээр буган хөшөөдийн дотроос хамгийн өвөрмөц бүсний дүрслэлтэй нэгэн хөшөө бол Шивээтийн буган хөшөө юм. Уг

хөшөөнд дүрслэгдсэн олон агсарга унжлагатай бүсний дүрслэл нь буган хөшөөний соёлын хүрээнд анх удаа бүртгэгдэж буй юм. Үүгээрээ маш чухал, ховор дүрслэлтэй буган хөшөөний тоонд зүй ёсоор тооцогдоно.

Үүнээс гадна Сантын овоо-1 дурсгалт газрын 1 дүгээр буган хөшөөний бүсэнд хавчуулан дүрслэсэн гүйвэр зэвсгийн дүрслэл нь маш ховор бөгөөд урьд нь Уушигийн өврийн 7-р буган хөшөө (Волков 2002, табл 76), Архангай аймгийн Хойд тамирын голын Хавцалын амны 41 дүгээр буган хөшөөнд (Гантулга нар 2016, 32) тус тус бүртгэгдсэн байна. Өөрөөр хэлбэл, Сантын овооны гүйвэр зэвсэг нь гурав дахь тохиолдол юм.

Товч дүгнэлт

Монголын умард нутгаас бидний шинээр илрүүлсэн 30 буган хөшөөний анхан шатны судалгааны үр дүнд тулгуурлан дараах товч дүгнэлтийг хийж байна.

1. Тус хошууны нутаг дэвсгэр нь эрт цагаас нүүдэлчдийн ахуй соёлын нэгэн идэвхтэй бүс нутаг байсан нь 3000 жилийн тэртээд бүтээгдсэн буган хөшөөдийн тархалтаас тодорхой харагдаж байна.

2. Бидний энэ удаагийн судалгааны үр дүнд энэ бүс нутагт урьд өмнө бүртгэгдсэн ердөө 25 буган хөшөө байсныг шинээр илрүүлсэн 30 буган хөшөөгөөр баяжуулж, нийт 25 дурсгалт газар 55 буган хөшөө буйг тогтоолоо.

3. Шинээр илрүүлсэн эдгээр 30 буган хөшөөний 90 хувь нь амьтны дүрслэлгүй буган хөшөө байгаа нь буган хөшөөний соёлын тархалтын хойд захын бүс нутгийн онцлогийг харуулж байна.

4. Хөшөөдөд дүрслэсэн эд зүйлс, зэр зэвсгийн ихэнх нь уг соёлын хүрээнд түгээмэл тохиолдох дүрслэлүүд байгаа боловч цөөн тооны буган хөшөөнд онцолж дурдууштай, сонирхолтой дүрслэлүүд буюу гүйвэр зэвсэг, хүзүүний зүүлт, ороомог дүрсүүд байна. Үүнээс хамгийн чухал нэгэн дурсгал бол Шивээтийн буган хөшөө юм. Энэ хөшөөнд урьд өмнө буган хөшөөнд огт дүрслэгдээгүй олон агсарга унжлагатай бүс, олон цувраа хонхор цэгээр илэрхийлсэн титэм, нүүрэн талд дүрсэлдэг гурван ташуу зураасыг төлөөлүүлсэн гурван хонхор цэг зэрэг нь энэ судалгааны маш чухал, шинэлэг баримт болж байна.

5. Эдгээр буган хөшөөдийн он цаг нь уг соёлын ерөнхий он цагийн хүрээнд буюу НТӨ 1300-700 оны хооронд хамаарах нь тодорхой боловч үнэмлэхүй он цаг тогтоох малтлага судалгаа хийж, илүү нарийвчилсан үр дүнд хүрч болох юм.

6. Орон нутгийн хүмүүсийн соёлын өвийн талаарх мэдлэг, мэдээлэл дутмагаас шалтгаалан эртний хөшөө, дурсгал маш ихээр сүйтгэгдэж, гэмтэж байгаагийн нэгэн жишээ нь Бугатын

дурсгалт газрын таван буган хөшөө юм. Тиймээс цаашид олон нийтэд соёлын өвийн үнэ цэнийг ойлгуулах, мэдлэг түгээх ажлыг эрчимжүүлэх шаардлагатай байна.

НОМ ЗҮЙ

Баяр, Д. “Монгол Алтайд шинээр олдсон зарим буган хөшөөнүүдийн тухай”. *Археологийн судлал*. 15 (5), Улаанбаатар, 1995: 53-64.

Баярсайхан, Ж. *Монголын умард нутгийн буган хөшөөд*. Улаанбаатар, 2017.

Баярсайхан, Ж., Анхсанаа, Г., Анхбаяр, Б. Хөвсгөл аймгийн Түнэл сумын нутгаас санамсаргүй илрүүлсэн эртний олдворуудыг соёлын яаманд шилжүүлэн авчрах, олдсон газрыг нягтлан шалгах судалгааны багийн тайлан. ШУА-ийн Археологийн хүрээлэн. Улаанбаатар, 2021.

Баярсайхан, Ж., Хүрэлсүх, С. “Монгол-Америкийн хамтарсан “Умардын хязгаар” төслийн 2022 оны хээрийн судалгааны тайлан”. ШУА-ийн Археологийн хүрээлэнгийн ГБСХ. Улаанбаатар, 2022.

Волков, В.В. *Оленные камни Монголии*. Москва, 2002.

Волков, В.В. *Оленные камни Монголии*. Улан-Батор, 1981.

Гантулга, Ж., Ерөөл-Эрдэнэ, Ч., Магай Ж. *Хойд тамирын буган чулуун хөшөө*. Улаанбаатар, 2016.

Даваацэрэн, Б., Анхсанаа, Г. “Буган чулуун хөшөөнд сийлсэн илдний тухай”. *Journal of the Archaeology, History and Culture, Journal of Ulaanbaatar State University*. 10 (9), 2014.

Диков, Н.Н. *Бронзовый век Забайкалья*. Улан-Удэ, 1958.

Эрэгзэн, Г., Баярсайхан, Ж., Хүрэлсүх, С., Миллер, А., Миллер, Б., Кларк, Ж., Хоммель, П. “Монгол-Америкийн хамтарсан “Умардын хязгаар” төслийн 2022 оны хээрийн судалгааны тайлан”. ШУА-ийн Археологийн хүрээлэнгийн ГБСХ., Улаанбаатар, 2022.

Эрэгзэн, Г., Баярсайхан, Ж., Юркенас, Д., Анхсанаа, Г., Амина, Ж., Хүрэлсүх, С., Фишер, М. “Монгол-Германы хамтарсан “MAPSS” төслийн 2023 оны археологийн хээрийн судалгааны тайлан”. ШУА-ийн Археологийн хүрээлэнгийн ГБСХ., Улаанбаатар, 2023.

REFERENCES

Bayar, D. “Mongol Altaid shineer oldson zariim bуган khöshöönüüdiin tukhai”. *Arkheologiin Sudlal*. 15 (5), Ulaanbaatar, 1995: 53-64.

Bayarsaikhan, J. *Mongolyn umard nutgiin bуган khöshööd*. Ulaanbaatar, 2017.

Bayarsaikhan, J., Ankhsanaa, G., Ankhbayar, B. *Khövsgöl aimgiin Tünel sumyn nutgaas sanamsargüi ilrüülen ertnii oldvoruudyg soyolyn yaamand shiljүүлэн avchrakh, oldson gazryn nygtlan shalgakh sudalgaany bagiin tailan*. Manuscript Archive of the Institute of Archaeology, Mongolian Academy of Sciences. Ulaanbaatar, 2021.

Bayarsaikhan, J., Khürelsükh, S. “Mongol-Amerikiin khamtarsan “Umardyn khiazgaar” töслийн 2022 ony kheeriin sudalgaany tailan”. Manuscript Archive of the Institute of Archaeology, Mongolian Academy of Sciences. Ulaanbaatar, 2022.

Volkov, V.V. *Olennye kamni Mongolii*. Moskva, 2002.

Volkov, V.V. *Olennye kamni Mongolii*. Ulan-Bator, 1981.

Gantulga, J., Yörööl-Erdene, Ch., Magai, J. *Khoid tamiryn bуган chuluun khöshöö*. Ulaanbaatar, 2016.

Davaatseren, B., Ankhsanaa, G. “Bуган chuluun khöshöond siilsen ildnii tukhai”. *Journal of the Archaeology, History and Culture, Journal of Ulaanbaatar State University*. 10 (9), 2014.

Dikov, N.N. *Bronzovy vek Zabaykal'ya*. Ulan-Ude, 1958.

Eregzen, G., Bayarsaikhan, J., Khürelsükh, S., Miller, A., Miller, B., Clark, J., Hommel, P. “Mongol-Amerikiin khamtarsan “Umardiin khiyazgaar” töслийн 2022 onii kheeriin sudlgaanii tailan”. Manuscript Archive of the Institute of Archaeology, Mongolian Academy of Sciences. Ulaanbaatar, 2022.

Eregzen, G., Bayarsaikhan, J., Khürelsükh, S., Miller, A., Miller, B., Clark, J., Hommel, P. “Mongol-Amerikiin khamtarsan “Umardiin khiyazgaar” töслийн 2023 ony kheeriin sudlgaanii tailan”. Manuscript Archive of the Institute of Archaeology, Mongolian Academy of Sciences. Ulaanbaatar, 2023.


Gantulga, J., Erööl-Erdene, Ch., Magai, J. *Khoit tamiriin bуган chuluun khöshöö*. Ulaanbaatar, 2016.




Open Access This is an open access article distributed in accordance with the Creative Commons Attribution Non Commercial (CC BY-NC 4.0) license, which permits others to distribute, remix, adapt, build upon this work non-commercially, and license their derivative works on different terms, provided the original work is properly cited, appropriate credit is given, any changes made indicated, and the use is non-commercial.

See: <http://creativecommons.org/licenses/by-nc/4.0/>


Хавсралт зураг




Зураг 1. А. Алтангадас уулын буган хөшөө, Б-Г. Төгөл модны 1,2,3 дугаар буган хөшөө, Д-3. Бугатын 1,2,3,4,5 дугаар буган хөшөө (Гар зургийг Ж.Баярсайхан).




Зураг 2. А. Шивээтийн буган хөшөө, Б-В. Цахир толгойн 1,2 дугаар буган хөшөө, Г-Е. Сантын овоо-1 дурсгалт газрын 1,2,3 дугаар буган хөшөө, Ё-3. Сантын овоо-2 дурсгалт газрын 1,2,3 дугаар буган хөшөө (Гар зургийг Ж.Баярсайхан).



Зураг 3. А-Б. Яргайтын амны 1,2 дугаар буган хөшөө, В-Ё. Саخالтын амны 1,2,3,4,5 дугаар буган хөшөө (Гар болон гэрэл зургийг Ж.Баярсайхан).



Зураг 4. А-Г. Цагаан толгой-1 дурсгалт газрын 1,2,3,4 дүгээр буган хөшөө, Д. Цагаан толгой-2 дурсгалт газрын буган хөшөө (Гар болон гэрэл зургийг Ж.Баярсайхан).



Зураг 5. Шинээр илрүүлсэн гучин буган хөшөөний ангилал



Зураг 6. Буган хөшөөдийн өнөөгийн нөхцөл байдал



Зураг 7. Буган хөшөөдийн өндрийн харьцуулалт